



УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан.



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлтийг хууль, тогтоомжийн дагуу хийсэн ч, удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зардалд зарцуулсан, зарим сум, байгууллагын зүгээс тавих дотоод хяналт сүл байна.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны зарцуулалт

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн: Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд Аудитын менежер Ж.Энхжаргал Ахлах аудитор С.Алтанхундага Ахлах шинжээч М.Батсуурь Аудитор Т.Намжил С.Батсайхан Шинжээч Зунгарав 2016 оны 4 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3721, 7045-3799 дугаарын утсаар харилцана уу. Хаяг: Үвс аймгийн Аудитын газар Улаангом сум З-р баg Аймгийн Засаг даргын тамгын газрын байр	<p align="center">Агуулга</p> <p>Товчилсон үгийн тайлал</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</p> <p align="center">Бүлэг 1: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөлж, хувиарласан байна</p> <p>1.1 Сумын Хөгжлийн индекс тодорхойгүй байгаагаас шалтгаалж Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах боломжгүй байна.</p> <p>1.1.1 ОНХС-аас аймаг нийслэлд олгох орлогын шилжүүлэгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн эсэх?</p> <p>1.1.2 Аймаг ОНХС-аас сумдын ОНХС-д олгох шилжүүлгийг төлөвлөхдөө сумын хөгжлийн индексийг хасаж үлдсэн 3 итгэлцүүр тэнцүү буюу 33 хувиар тооцсон байна.</p> <p>1.1.3 Аймаг, нийслэл, сум дүүргийн ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан зарим нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.</p> <p>1.2 ОНХС-аас олгосон шилжүүлгийг сум, дүүргийн ОНХС-д хувиарлахдаа холбогдох журмыг баримталсан байна.</p> <p>1.2.1 Аймгийн ОНХС-д орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийг хууль, журмын дагуу тооцож хуваарилсан уу?</p> <p>1.2.2 Аймгийн ОНХС-аас сумдын орон нутгийн хөгжлийн санд олгосон шилжүүлгийг хууль, журамд заасан үзүүлэлтээр хуваарилсан хэдий ч тооцох аргачлалыг мөрдөөгүй байна.</p> <p>1.3 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан, иргэдийн саналыг авсан байна.</p> <p>1.3.1 Үес аймагт 2015 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн ажлын 85 хувь нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.</p> <p>1.3.2 Аймаг, сум 2015 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авсан байна.</p> <p>1.3.3 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийг иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлэгүй байна.</p> <p>1.3.4 Багийн иргэдээс санал аваагүй зарим хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийг эрэмбэлж төлөвлөгөөнд тусгасан байна.</p> <p>1.4 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх томоохон ажлуудын төсөвт өргтийг урьдчилан тооцсон, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан байна.</p> <p>1.4.1 Аймгийн Худалдан авах ажиллагаанаас худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 8 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв батлагдсан байна</p> <p>1.4.2 Хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд тусгагдсан томоохон ажлуудад шаардагдах хөрөнгө, төсөвт өргтийг тооцсон байна.</p> <p>1.5 Аймаг, зарим сумдын ИТХ ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэж батлахдаа холбогдох эрх зүйн актыг баримталсан байна.</p>	1-3 4 5 6 6 6 6 6 6-7 6 7-8 8 8 8-10 10 10-11 11-12 12 12-13 13 13 13 13 13 13
--	--	--

	1.5.1 Аймаг, сумдын ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг төсөл тус бүрээр хэлэлцэж баталсан байна.	13
	1.5.2 Багийн ИНХ-аар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг аймаг, зарим сумын ЗДТГ-аас батлуулсан байна.	14
	Дүгнэлт	14
	Зөвлөмж	14
	Булэг 2: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлсэн боловч удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зардалд зарцуулсан байна.	15
	2.1. Ус аимгийн хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль журамд заасан 2 нэр төрлөөр бүрдүүлсэн байна.	15
	2.1.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн үндсэн тэнцилийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг журмын дагуу тооцоолон ОНХС-ийн орлогод 550.0 сая төгрөг төвлөрүүлэн зарцуулсан байна.	15
	2.1.2 Аймаг, сумын татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар ОНХС-д төвлөрүүлсэн орлого байхгүй байна.	15
	2.1.3 Аймаг, сумын зардлыг хэмнэж бий болгож ОНХС-д төвлөрүүлсэн орлого байхгүй байна.	15
	2.1.4 Зарим сум ойн хандивын 597.6 сая төгрөгийн орлогыг ОНХС-ийн эх үүсвэрт төвлөрүүлэн зарцуулсан байна.	15
	2.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалт, гүйцэтгэлийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан чадраах зөрчил байна.	15-17
	2.2.1 ОНХС-ийн хөрөнгөнөөс удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зардалд зориулалт бусаар зарцуулсан байна.	17-18
	2.2.2 Төсөл, хөтөлберийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.	18
	2.2.3 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ажил гүйцэтгүүлэх гэрээг ажлын хэсэг болон үнэлгээний хорооноос гаргасан зөвлөмжийг үндэслэн байгуулсан байна.	18
	2.2.4 Төсөл хөтөлберийн хэрэгжилтэнд захиалагчийн хяналтыг тавьсан ч төсвийн хүндэлзээс шалтгаалан санхүүжилт дутуу олгогдсон байна.	18
	2.2.5 ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын санхүүжилт хасагдаж ирснээс гүйцэтгэг компанийт байгуулсан гэрээний хугацааг сунгасан байна.	18
	2.2.6 ОНХС-ийн санхүүжилт дутуу ирснээс аймаг, сумын ОНХС-ийн санхүүжилтийг бүрэн олгоогүй байна.	19-20
	2.3 ОНХСангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг комисс хүлээн авсан ч зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	20
	2.3.1 ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг эрх бүхий байгууллагаас томилогдсон комиссын дүгнэлтээр хүлээн авч ажилласан байна.	20
	2.3.2 ОНХСангийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	20
	Дүгнэлт	20
	Зөвлөмж	21
	Булэг 3: ОНХС-ийн зарцуулалтад тавих хяналтыг зохион байгуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн ч зарим сум, байгууллагын зүгээс тавих дотоод хяналт суп байна.	21
	3.1 ОНХС-ийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд хууль, журмын дагуу хяналт тавьсан байна.	21

Үес аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны зарцуулалт

	3.1.1 Зарим сүм байгууллагын зүгээс ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд тавих дотоод хяналт сүл байна.	21-22
	3.2 ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэж буй ажлын гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтыг олон нийтэд илт тод мэдээлсэн байна.	22
	3.2.1 Аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулал, төсөл, арга хэмжээний жагсаалт төсөвт өртгийг иргэдэд мэдээлсэн байна.	22
	3.2.2 Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Шилэн дансны тухай хуулийн шаардлагыг хангаж ажилласан байна.	22-23
	3.3 Өмнөх оны аудитаар өгсөн акт 100 хувь, албан шаардлага 97.45 хувь, зөвлөмж 98 хувь хэрэгжүүлсэн байна.	23
	3.3.1 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.	23
	3.3.2 Аудитаар өгсөн 13 акт, 50 албан шаардлагыг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна	23-27
	<i>Дүгнэлт</i>	27
	<i>Зөвлөмж</i>	27
	<i>Санал асуулгын нэгтгэл</i>	28
	<i>Холбогдох байгууллагын санал</i>	29-31
	<i>Аудитын газраас өгөх тайлбар</i>	32

Товчилсон үгийн тайлал:

- ОНХНС – Орон унтгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС – Орон нутгийн хөгжлийн сан
СС – Сангийн сайд
ЗДТГ – Засаг даргын тамгын газар
ИТХ – Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ – Иргэний нийтийн хурал
ТЭЗҮ – Техник эдийн засгийн үзүүлэлт
ТББ – Төрийн бус байгууллага
ХХК – Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил
үйлчилгээ худалдан авах тухай
ГХБХБГ – Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ХХЦГ – Хотын хөгжил цэцэрлэгжүүлэлтийн газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийллээ.

2. Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитыг дараах зорилтын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлж, зарцуулсан эсэх.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн эсэх.

3. Хамарсан хүрээ

Орон нутгийн хөгжлийн санд 2015 онд аймаг, сумдад улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн төлөвлөж зарцуулсан талаар тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан болон бусад холбогдох материалд тулгуурлан аймаг, сумын ИТХ, ЗДТГ, төрийн байгууллагуудыг хамруулав.

4. Арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох байгууллагын албан тушаалтуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, иргэдээс санал асуулга авч нэгтгэх, санхүүгийн тайлан, хөрөнгийн бүртгэл, анхан шатны баримтыг ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах, аймгийн Худалдан авах ажиллагааны алба, байгууллагын худалдан авах үйл ажиллагааны зохион байгуулалт, хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь үзэж баталгаажуулах, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулах, мэдээ судалгаанд тулгуурлан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Нийцлийн аудитыг аймгийн Аудитын газрын ахлах аудитор С.Алтанхундага, ахлах шинжээч М.Батсуурь, аудитор Т.Намжил, С.Батсайхан, шинжээч Я.Зунгарав нар хийж гүйцэтгэллээ.

Бүлэг1: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хувиарласан байна

1.1. Сумын Хөгжлийн индекс тодорхойгүй байгаагаас шалтгаалж Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах боломжгүй байна.

1.1.1. ОНХС-аас аймаг нийслэлд олгох орлогын шилжүүлэгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн эсэх?

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлд олгох эх үүсвэртэй холбоотой асуудал тул орон нутагт хамааралгүй болно.

1.1.2. Аймаг ОНХС-аас сумдын ОНХС-д олгох шилжүүлгийг төлөвлөхдөө сумын хөгжлийн индексийг хасаж үлдсэн 3 итгэлцүүр тэнцүү буюу 33 хувиар тооцсон байна.

Төсвийн тухай хуулийн 59.3-д аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг төлөвлөхөд шаардлагатай итгэлцүүрийг тодорхой тусгасан байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн индекс
- Хүн амын тоо
- Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ
- Орон нутгийн татварын идэвх санаачилга

Засгийн газрын 2012 оны 30 тоот тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” журмын 1-р хавсралтанд “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 3.2-т орон нутгийн хөгжлийн индекс 25 хувь, хүн амын тоо 25 хувь, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ 25 хувь, орон нутгийн татварын идэвхи санаачилга 25 хувиар тооцож Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг тооцож төлөвлөхөөр тусгажээ.


Засгийн газрын 2014 оны 242 тоот тогтоолоор “Сумын хөгжлийн индекс тооцох аргачлал”-ыг 2 жил тутам шинэчлэн баталж байхыг Эдийн засгийн хөгжлийн яаманд даалгасан ч 2016 оны 4 дүгээр сарын байдлаар уг индексийг тооцоолох аргачлал шинэчлэн батлагдаагүй байна.

Үвс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох эх үүсвэрийг төлөвлөхдөө Засгийн газрын 2012 оны 30 тоот тогтоолын 1-р хавсралтын 9.4-д “Энэ аргачлалын 3.2.1-д заасан орон нутгийн хөгжлийн индексийг сум, дүүргийн түвшинд үнэн зөв, бодитой байдлаар гаргах боломжтой болох хүртэлх хугацаанд уг индексэд харгалзах 25 хувийг аргачлалын 3.2.2-3.2.4-т заасан үзүүлэлтүүдэд тэнцүү хуваарилах байдлаар орлуулан хэрэглэж болно” гэж заасны дагуу хөгжлийн индексээс бусад итгэлцүүрийг тэнцүү буюу 33 хувиар тооцжээ.

Төсвийн тухай хуулийн 59.2-т аймаг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сумын хөгжлийн санд уг хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хувиарлахаар заасны дагуу 2015 онд Орон нутгийн

хөгжлийн нэгдсэн сангаас хувиарлахаар төлөвлөсөн 4693.1 сая төгрөгийн 40 хувь буюу 1885.6 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 60 хувь буюу 2807.5 сая төгрөгийг 19 сумын ОНХС-д тус тус хувиарлахаар төлөвлөсөн байна.

/ сая.төг/



1.1.3. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан зарим нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.

Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 6.1, 6.2-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны ОНХС-ийн эх үүсвэрийг дараах хүчин зүйлсээс бүрдүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- ОНХС, ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр
- Зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр
- Тухайн орон нутгийн орлогыг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив тусламж

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрт 2015 онд ОНХС-аас 4693.1 сая, аймгийн орон нутгийн орлогоос 136.4 сая, өмнөх оны үлдэгдлээс 640.6 сая, нийт 5470.1 сая, сумдын ОНХС-ийн эх үүсвэрт 2015 онд аймгийн ОНХС-аас 2807.5 сая, өмнөх оны үлдэгдлээс 189.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Ой зохион байгуулсан Малчин сум 400.0 сая, Тариалан сум 482.2 сая, Түргэн сум 250.0 сая, Сагил сум 200.0 сая, Завхан сум 100.0 сая, нийт 1432.2 сая төгрөгийг сумын ОНХС-д хандив тусламжаас бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

ОНХС-аас олгосон шилжүүлгийг сумдын ОНХС-д хувиарлахдаа холбогдох журмыг баримталсан байна.

1.1.4. Аймгийн ОНХС-д орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийг хууль, журмын дагуу тооцож хуваарилсан уу?

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлд олгох эх үүсвэртэй холбоотой асуудал тул орон нутагт хамааралгүй болно.

1.1.5. Аймгийн ОНХС-аас сумдын орон нутгийн хөгжлийн санд олгосон шилжүүлгийг хууль, журамд заасан үзүүлэлтээр хуваарилсан хэдий ч тооцох аргачлалыг мөрдөөгүй байна.

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 9.2-д “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн 60 –аас доошгүй хувийг сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилахад энэ аргачлалын 3-р дугаар зүйлд заасан мэдээллийг ашиглан мөн аргачлалын 4-8 дугаар зүйлд заасан итгэлцүүрүүдийг орон нутгийн үзүүлэлтэд дүйцүүлэн тогтооно” гэж заасныг зөрчин Улаангом суманд илүү, бусад сумдад дутуу хуваарилсан байна.


Тухайлбал: Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 5.4-д “Тухайн аймаг, **суманд** оршин сууж байгаа хүн амын тоог хүн амын нийт тоонд харьцуулсан харьцааг хүн амын тооноос хамааран хуваарилах эх үүсвэрийн дүнгээр үржүүлж тухайн аймаг, нийслэлд олгох дүнг тодорхойлно” гэж заасны дагуу дараах байдлаар хувиарласан байна.

Д/д	Сумдын нэр	Хүн амын тоо	Хүн амын тооноос хамруулан олгосон дүн	Хүн амын тооноос хамруулан олгох дүн /сая.төг/	Зөрүү /сая.төг/
1	Баруунтуруун	2385	26.0	29.6	-3.6
2	Бөхмөрөн	2180	23.8	27.0	-3.2
3	Давст	1748	19.1	21.7	-2.6
4	Завхан	1722	18.8	21.3	-2.5
5	Зүүнговь	2413	26.3	29.9	-3.6
6	Зүүнхангай	2231	24.3	27.7	-3.4
7	Малчин	2404	26.2	29.8	-3.6
8	Наранбулаг	4356	47.5	54.0	-6.5
9	Өлгий	2121	23.1	26.3	-3.2
10	Өмнөговь	4348	47.4	53.9	-6.5
11	Өндөрхангай	3155	34.4	39.1	-4.7
12	Сагил	2267	24.7	28.1	-3.4
13	Тариалан	3679	40.1	45.6	-5.5
14	Түргэн	2015	22.0	25.0	-3.0
15	Тэс	5280	57.6	65.4	-7.8
16	Ховд	2222	24.2	27.5	-3.3
17	Хяргас	2426	26.4	30.1	-3.7
18	Цагаанхайрхан	1972	21.5	24.4	-2.9
19	Улаангом	26594	402.6	329.6	73.0
Нийт		75518	936.0	936	0.0

Хүн амын тооноос хамааран хуваарилсан дээрх тооцооллоос үзэхэд Улаангом сумын ОНХС-д 73.0 сая төгрөгийг илүү бусад сумдад 2.9-7.8 сая хүртэл төгрөг буюу нийт 73.0 сая төгрөг дутуу хуваарилсан байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас Улаангом сумын ОНХС-д хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах шилжүүлгээр 73.1 сая, Орон нутгийн татварын идэвх санаачлагаас хамаарах шилжүүлгээр 121.6 сая төгрөгийг хэрхэн тооцоолж хуваарилсан нь тодорхойгүй байна.

Монгол улсын төсөв санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Үвс аймгийн ОНХСанд олгох орлогын шилжүүлэг анх батлагдсан дүнгээс 2980.6 сая, тодотгол хийгдсэн дүнгээс 788.3 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна. Үүнийг графикаар харуулбал:



Төсвийн тухай хуулийн 59.2-д “Аймаг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сумын ОНХС-д энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна” гэж заасан байхад ОНХСангаас олгох орлогын шилжүүлгийг дутуу санхүүжүүлснээс аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээс сумын орон нутгийн хөгжлийн санд 52.9 хувийг хуваарилсан байна.

Үзүүлэлт	Анх батлагдсан төлөвлөгөө	Тодотгосон төлөвлөгөө	Санхүүжсэн дүн
Аймгийн ОНХС	2989.0	1871.7	1833
Сумын ОНХС	4483.5	2807.5	2057.9
НИЙТ ДҮН	7472.5	4679.2	3890.9
Сумын ОНХС эзлэх хувь	60%	60%	52.9%

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт хуваарилсан шилжүүлгийг сумдад хуваарилсан төлөвлөгөө, тодотгосон төлөвлөгөө, олгосон санхүүжилт дараах байдалтай байна.

№	Сум	Анх батлагдсан	Тодотгосон 2015.03.30	Тодотгосон 2015.11.26	Сая.төг Санхүүжсэ н дүн
1	Баруунтуруун	185.5	116.2	116.2	70.0
2	Бөхмөрөн	194.6	121.9	121.9	75.0
3	Давст	219.7	137.6	137.6	95.0
4	Завхан	251.9	157.7	157.7	110.0
5	Зүүнговь	176.9	110.8	110.8	95.0
6	Зүүнхангай	194.9	122.1	122.1	75.0
7	Малчин	186.7	116.9	116.9	80.0
8	Наранбулаг	217.7	136.3	136.3	90.0
9	Өлгий	164.9	103.3	103.3	65.0
10	Өмнөговь	206.3	129.2	129.2	100.0
11	Өндөрхангай	226.3	141.7	141.7	90.0
12	Сагиль	182.5	114.3	114.3	90.0
13	Түргэн	187.0	117.1	117.1	82.0
14	Тариалан	140.4	87.9	87.9	87.9
15	Тэс	219.9	137.7	137.7	127.0
16	Хяргас	190.1	119.1	119.1	75.0
17	Ховд	194.9	122.1	122.1	80.0
18	Цагаанхайрхан	189.0	118.4	118.4	75.0
19	Улаангом	954.2	597.3	597.3	496.0
Нийт дүн		4483.5	2807.5	2807.5	2057.9

1.2. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан, иргэдийн саналыг авсан байна.

1.2.1. Үвс аймагт 2015 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн ажлын 85 хувь нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.


Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 2.2-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь УИХ, Засгийн газар болон тухайн орон нутгийн хөгжлийн талаар баримталж байгаа бодлого стратеги, түүнтэй холбогдох бусад бичиг баримттай уялдсан байна” гэж заажээ.

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийг Увс аймгийг хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан тодорхойлж аймгийн ИТХ-аар батлуулан ажиллажээ.

Харин сумдын хувьд хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл нь сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зарим зүйл заалтаар тодорхойлогдож байна.

Увс аймгийн хэмжээнд 2015 онд аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр 34, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр 241 буюу нийт 275 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аас баталжээ.

Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр 2015 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс аймгийн ИТХ-ын 2008 оны 08/01 тоот тогтоолоор баталсан “Үвс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр /2008-2021 он/”-т тусгагдсан орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй 233 төсөл, арга хэмжээ уялдсан байна. Графикаар харуулбал:



1.2.2. Аймаг, сум 2015 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авсан байна.

Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалын 12.1-д “аймаг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэд олон нийтийн саналыг цахим хуудас, санал асуулгын хуудас ашиглах, ярилцлага зохион байгуулах болон дэвшилтэд технологийн бусад хэлбэр ашиглах замаар явуулна”, 12.2-т “Сум ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэд олон нийтийн оролцоог санал асуулгын хуудас ашиглах, бүлгийн ярилцлага, цахим хэлбэрээр авна” гэж заажээ.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө 2014 оны 11 дүгээр сарын 1-нээс 17-ны хооронд www.uvs.gov.mn цахим хуудсаар нээлттэй санал авсан байна.

Санал асуулгад нийт 3119 иргэн хамрагдаж 10 төрлийн ажилд санал ирүүлсэн байна.

Д/д	Хийгдэх ажлын санал	Саналын тоо	Саналын хувь
1	Номын сангийн Электрон каталогийг интернэтэд байршуулах	1944	62.3
2	Хүүхдийн ордон	1073	34.3
3	Баруунтурууны спорт заал засварлах	27	0.9
4	Хүүхдийн зуслан	23	0.7
5	Кино театр	16	0.5
6	Усан бассейн	12	0.4
7	Баруунтуруун сумын сургуулийн дотуур байр засварлах	9	0.3
8	Хүүхдийн цэцэрлэг	5	0.2
9	Баруунтуруун сумын эмнэлгийн угаалгын байр засварлах	5	0.2
10	Дулааны цахилгаан станц	5	0.2
		3119	100

Харин ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээнд Давст, Сагил, Улаангом, Өмнөговь, Өлгий, Түргэн, Зүүнхангай сумууд 2015 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөн батлахдаа иргэдийн санал авсан гэх боловч нотлох саналын хуудас бодитоор байхгүй байна. Цаашид ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний нотлох анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж ажиллах нь зүйтэй.

1.2.3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийг иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлээгүй байна.

Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалын 12.1.3-д “аймаг, нийслэлийн засаг дарга олон нийтээс хамгийн их санал авсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн иргэд олон нийтэд танилцуулна”, Сангийн сайдын 2014 оны 43 тоот зөвлөмжийн 6.6-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэд, олон нийтээс хамгийн их санал авсан, ажлын хэсгийн санал дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн иргэд, олон нийтэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон иргэний танхимаар дамжуулан 11 дүгээр сарын 30-ны дотор танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулна” гэж заасан байна.

Аудитын явцад аймгийн Иргэний танхимын ажилтан аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн урьдчилсан саналын жагсаалтыг иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлээгүй гэсэн тайлбар өгсөн бөгөөд хэлэлцүүлсэн баримт байхгүй байна.

1.2.4. Багийн иргэдээс санал аваагүй зарим хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийг эрэмбэлж төлөвлөгөөнд тусгасан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө сумууд иргэдийн саналыг хууль, тогтоомжийн дагуу нэгтгэн Багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн, хурлын тэмдэглэл хөтлөн, эрэмбэлсэн жагсаалтыг Багийн ИНХ-ын тогтоолоор баталгаажуулан сумын ЗДТГ-т хүргүүлсэн байна.

Сангийн сайдын 43 тоот тушаалаар батлагдсан журмын 3.5-д “Засаг даргын Тамгын газар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тухайн шатны ИТХ-д хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлэхдээ тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан талаар дэлгэрэнгүй тайлбар үндэслэл иргэдийн хурлаас гарсан санал, тэдгээрийг тусгасан байдал гэсэн, дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргана” гэж заасны дагуу сумдын ЗДТГазар Багийн иргэдийн нийтийн хурлаас эрэмбэлж ирсэн жагсаалтыг нэгтгэн дахин эрэмбэлж нэгдсэн саналын жагсаалтыг сумын ИТХ-д хүргүүлсэн байна.

Гэтэл аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд иргэдээс цахим хуудсаар нээлттэй санал авч саналыг нэгтгэсэн ч иргэдээс ирсэн саналыг тусгaaгүй байна. Аймгийн ИТХ-ын 2015 оны 10/06 тоот тогтоолоор баталсан 2015 онд ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтыг хавсралт хүснэгт №1 харуулав.

1.3. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх томоохон ажлуудын төсөвт өртгийг урьдчилан тооцсон, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан байна.

1.3.1. Аймгийн Худалдан авах ажиллагаанаас худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 8 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв батлагдсан байна

Төсвийн тухай хуулийн 29.4-д “хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн зураг төсвөө батлуулсан хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана”, Барилгын тухай хуулийн 15.2-д “Зураг төсөвгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно” гэж заажээ.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хийгдэхээр 34 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна. Үүнээс аймгийн Худалдан авах ажиллагааны албанаас худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 8 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв батлагдсан байна.

1.3.2. Хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд тусгагдсан томоохон ажлуудад шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцсон байна.

Үвс аймгийн Хөгжлийн стратеги төлөвлөгөө /2008-2021/, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Аймгийг хөгжүүлэх 2015 оны үндсэн чиглэл, нийгэм эдийн засгийн зорилтын хүрээнд гаргасан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт тусгагдсан зарим ажлын ТЭЗҮ, зураг төсвийг баталж төсөвт өртгийг тооцсон байна.

Тухайлбал:

- Галдан бошигт хорооллын гадна инженерийн шугам сүлжээ татах 302.0 сая
- Наадмын талбайн гадна тохижилт, /авто зогсоол, явган зам, ариун цэврийн байгууламж, цахилгаан хангалт/ 566.4 сая

1.4. Аймаг, зарим сумдын ИТХ ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэж батлахдаа холбогдох эрх зүйн актыг баримталсан байна.

1.4.1. Аймаг, сумдын ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг төсөл тус бүрээр хэлэлцэж баталсан байна.

1.4.2. Багийн ИНХ-аар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг аймаг, зарим сумын ЗДТГ-аас батлуулсан байна. Тухайлбал:

Аймгийн ОНХС-аас багийн иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Эдийн засгийн чуулган 10.0 сая
- 3 сая дахь иргэнд орон сууцны дэмжлэг үзүүлэх 70.0 сая
- Аймгийн Засаг даргын нэрэмжит “Аваргын өсвөрийн гараа” жудо, чөлөөт, үндэсний бөхийн тэмцээн 30.0 сая

■ Жүдо бөхийн өсвөр үеийн УАШТ 23.0 сая

Улаангом сум ОНХС-аас багийн иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Эрүүл хот хөтөлбөрийн хүрээнд “Миний хайртай улаангом” ТББ-д шилжүүлэн морин хуур 5000.0 мянга, Улаангом сумын ЗДТГ-ын үүдний зогсоол 2060.0 мянга, Улаангом сумын ногоон бүсийн талбайд мод тарих үрсэлгээний үнэ 92.0 мянга, Улаангом сумын ЗДТГ-ын үүдний ногоон байгууламжийн хашлага хийхэд 468.2 мянга, шонгийн дарцагны суурь 565.6 мянга, замын хажууд хайрага дэвсэх 1154.2 мянга, утас багцлагчийн үнэ 49.0 мянга, арматурын үнэ 611.0 мянга, нийт 10.0 сая
- Улаангом сум Баялаг бүтээгч Улаангом хөтөлбөрийн хүрээнд “Ном хур” ХХК-д шилжүүлэн “Баялаг бүтээгч Улаангом” нэртэй 1500 ширхэг ном хэвлүүлсэн 9.4 сая, эх бэлтгэл 0.3 сая, тээврийн зардал 0.3 сая, нийт 10.0 сая

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 60.3, Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалаар батлагдсан журмын 6.3 дах заалтуудыг үндэслэн төлөвлөгүй байна.
2. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д 52.9 хувь буюу 2057.9 сая төгрөг хуваарилсан байна.
3. ОНХС-аас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг анх батлагдсан дүнгээс 2980.6 сая, тодотгол хийгдсэн дүнгээс 788.3 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Зөвлөмж: Үес аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга Д.Цэндсүрэн, сумдын Засаг дарга нарт:

1. Төсвийн тухай хуулийн 58-р зүйл, Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримталж ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлах.
2. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдад олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хууль, Засгийн газрын 30-р тогтоолын дагуу бүрэн шилжүүлэх.

Бүлэг 2: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлсэн боловч удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зардалд зарцуулсан байна.

2.1. Үвс аймгийн хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль журамд заасан 2 нэр төрлөөр бүрдүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрт 2015 онд ОНХС-аас 3890.9 сая, аймгийн орон нутгийн орлогоос 550.0 сая, өмнөх оны үлдэгдлээс 51.6 сая, нийт 4492.5 сая төгрөгийн санхүүжилт төвлөрүүлэн зарцуулсан байна.

2.1.1. Аймаг төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг журмын дагуу тооцоолон ОНХС-ийн орлогод 550.0 сая төгрөг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Орон нутгийн орлогоос 550.0 сая төгрөгөөр аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, аймгийн ИТХ-аар баталсан хавсралт судалгаанд хамрагдсан ажлуудад зарцуулсан байна.

2.1.2. Аймаг, сумын татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар ОНХС-д төвлөрүүлсэн орлого байхгүй байна.

2.1.3. Аймаг, сумын зардлыг хэмнэж бий болгож ОНХС-д төвлөрүүлсэн орлого байхгүй байна.

2.1.4. Зарим сум ойн хандивын 597.6 сая төгрөгийн орлогыг ОНХС-ийн эх үүсвэрт төвлөрүүлэн зарцуулсан байна.

Зарим сумууд ИТХ-аар баталж ойн хандивыг сумын ОНХС-д төвлөрүүлэн, ойн утгаж хийгдсэн сумын тохижилт, бүтээн байгуулалт, ойн арга хэмжээнд зарцуулсан байна.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалт, гүйцэтгэлийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан ч дараах зөрчил байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөнөөс удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зардалд зориулалт бусаар зарцуулсан байна.

Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан журмын 4.4-д “Аймаг, сумын удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахгүй байх” гэж заасныг зөрчин аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрээс дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчлийг давтан гаргахгүй байхыг зөвлөмж болголоо. Үүнд:

- Аймгийн ОНХС-аас санхүүжүүлсэн Боловсрол хөтөлбөрийн хүрээнд Япон улсад туршлага судлах багш нарт дэмжлэг 10.0 сая, Ховд, Говь-Алтай, Архангай аймгийн оюутнуудад дотуур байрны тэтгэлэг 9.2 сая, Олон улсын аврага шалгаруулах тэмцээний шагналд 4.8 сая, нэг анги-1000 бодлого уралдааны шагнал 3.2 сая, нийт 27.2 сая
- Аймгийн ОНХС-аас санхүүжсэн Эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд сургалт хийсэн багшийн зардалд 0.96 сая
- Улаангом сум Нийтийн биеийн тамир хөтөлбөрийн хүрээнд “Миний хайртай Улаангом” ТББ-д шилжүүлж аймгийн 90 жилийн ойн сур харвааны шагнал 6.4 сая, Улаангом дэвжээний дасгалжуулагчийн урамшуулалд 2.6 сая, 7-р багийн спортын өдөрлөгийн шагнал, үйл ажиллагааны зардалд 1.0 сая, нийт 10.0 сая
- Улаангом сум Нийтийн тээврийн үйлчилгээ хөтөлбөрийн хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээнд хамрагдсан өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийн төлбөрт 32.8 сая
- Түргэн сум сумын 90 жилийн ойн баримтат кино хийхэд 14.0 сая, түймэр унтраахад шатахуун, хоол 2.9 сая, зудад шатахуун 1.0 сая, нийт 17.9 сая
- Ховд сум хүүхэд хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийг зусланда гаргахад шатахуун, хоолны зардалд 0.9 сая
- Хяргас сум ном, авьяас хөтөлбөрийн хүрээнд уралдаан тэмцээний шагналд 3.1 сая
- Ховд сумын харилцаа холбоо үйлчилгээний дэд бүтэц байгуулах ажил, интернетийн төлбөр 9.9 сая төгрөгөөр гэрээ байгуулсан боловч 10.0 сая төгрөг шилжүүлж интернетийн төлбөрт 49.5 мянга
- Түргэн сум спорт, аялал жуулчлалыг дэмжих зардлаас Улсын арслан Н.Батсуурьт хүндэтгэл үзүүлэхэд 1.0 сая

Төсвийн тухай хуулийн 6.3.4-д “Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусlamж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, 60.3.5-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авахыг хориглоно” гэж заасны зөрчиж зориулалт бус зардал гаргасныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.


- ⊕ Түргэн сумын ОНХС-д төвлөрүүлсэн ойн хандиваас өндөр настан Н.Дариймаад 2.5 сая төгрөгийн зээл олгосноос 2.0 сая төгрөгийг төлөөгүйд.
- ⊕ Баруунтуруун сум Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3.1 км замын зураг төсвийн үнэ 2.0 сая төгрөгийг сумын ОНХС-аас 2014 онд гаргасан байна. Уг ажлыг гүйцэтгэх 2015 оны гэрээнд зураг төсвийн үнийг тусгасан боловч сумын ОНХС-д буцаан төвлөрүүлээгүй байсанд.

Түүнчлэн Өлгий сумын малжуулахад зориулан иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 2013 онд 6 малчинд 18.0 сая, 2014 онд 6 малчинд 18.0 сая, 2015 онд 7 малчинд 18.0 сая, нийт 19 малчинд 54.0 сая төгрөг олгоходо зээлийн гэрээ байгуулаагүйд зөрчил арилгах албан шаардлага өглөө.

2.2.2. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.3, 47.6 дахь заалтуудаар үнэлгээний хороонд тавигдсан шаардлагыг хангасан ажилтны нөөц боломж сум, орон нутагт дутагдалтай байна.

Аймгийн хэмжээнд ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг дараах байдлаар сонгон шалгаруулсан байна.



Засгийн газрын 2013 оны 68 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”-аар шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг 10.0 сая төгрөг байхаар тогтоосныг зөрчиж Өлгий сум ОНХС-аас 18.0 сая төгрөгөөр малжуулах төсөл хэрэгжүүлэхдээ шууд худалдан авалт хийсэн байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны алба ОНХС-аас хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулахдаа үнэлгээний хороог хуулийн хугацаанд нь ажиллуулж шийдвэр гарган зөвлөмжийг захиалагчид хүргүүлж байжээ.

ТБОНӨХБАУХАТ-ын хуулийн 11-р зүйлд “техникийн тодорхойлолт бэлтгэхдээ хангах шаардлагыг тодорхой тусгасан байна” гэж заасан байхад бараа худалдан авах гэрээний техникийн нөхцөлд нийлүүлэх ажил, үйлчилгээний нэр, тоо ширхэг, үнийг тодорхой тусгаагүй нь хуулийн холбогдох заалттай зөрчилдэж байгаа ба өндөр үнэтэй, чанаргүй бараа нийлүүлэх эрсдэл үүсэж байна. Тухайлбал:

- Улаангом сум Эрүүл хот хөтөлбөрийн хүрээнд “Миний хайртай улаангом” ТББ-д 10.0 сая
- Өлгий сум Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж нийлүүлэх 3.0 сая
- Бөхмөрөн сум Цэцэрлэгийн хүүхдийн тоглоом нийлүүлэх 5.0 сая
- Улаангом сум Боловсрол хөтөлбөрийн хүрээнд Ахлах 4-р сургуульд камер нийлүүлэх 4.5 сая, Улаангом сумын 6-р цэцэрлэгийн гадна тохижилт 7.0 сая, нийт 11.5 сая
- Өмнөговь сум Цагдаагийн байрны асуудал шийдвэрлэхэд 4.3 сая, Орон нутгийн телевиз 18.0 сая, насос 2.0 сая, зураг төсвийн үнэ 3.0 сая, нийт 27.3 сая

2.2.3. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ажил гүйцэтгүүлэх гэрээг ажлын хэсэг болон үнэлгээний хорооноос гаргасан зөвлөмжийг үндэслэн байгуулсан байна.

2.2.4. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд захиалагчийн хяналтыг тавьсан ч төсвийн хүндрэлээс шалтгаалан санхүүжилт дутуу олгогдсон байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилтээр хийгдсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд захиалагчийн хяналтыг тавьж ажилласан байна.

ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг дутуу олгосноос Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3 дах зүйлд заасны дагуу санхүүжилтийг олгоогүй байна.

2.2.5. ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын санхүүжилт хасагдаж ирснээс гүйцэтгэгч компанийтай байгуулсан гэрээний хугацааг сунгасан байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын санхүүжилт хасагдаж ирснээс зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хийгдэхгүй байх, санхүүжилт дутуу олгогдох, гэрээний хугацаа хэтрэх, дахин гэрээ байгуулах эрсдэл үүсгэсэн байна. Тухайлбал:

- ❖ “Дэвшил Увс” ХХК Гиваан баатарын талбайн ажлыг 2015 оны 8 дугаар сарын 22-нд ашиглалтанд оруулах гэрээ байгуулсан боловч санхүүжилтийн дутуугаас шалтгаалан 2016 оны 5 дугаар сарын 25-нд хүлээлгэн өгөхөөр дахин гэрээ байгуулсан байна.



Мөн дээрх шалтгаанаас хамаарч 2015 онд аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрээс хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээнээс нийт 43 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

2.2.6. ОНХС-аас санхүүжилт дутуу ирснээс аймаг, сумын ОНХС-ийн санхүүжилтийг бүрэн олгоогүй байна.

ОНХС-аас олгох санхүүжилт 2014, 2015 онуудад төлөвлөснөөс бага хэмжээтэй хуваарилагдаж ирснээс аймгийн ОНХС-аас 10 ажлын 227.0 сая, сумдын 749.6 сая, нийт 976.6 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.

Аймагт дутуу олгосон санхүүжилт

сая.төгрөг

№	Сум	Анх батлагдсан	Тодотгосон дүн	Санхүүжсэн дүн	Дутуу санхүүжилт
1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	50.0	50.0		50.0
2	Ховд сумын ЭМТ-ийн засвар	3.5	3.5		3.5
3	Спорт заал, бөхийн танхимын засвар	63.3	63.3	45.0	18.3
4	Эрүүл мэндийн төсөл хөтөлбөр /хорт хавдрын шалтгааныг тогтоох судалгаа/	11.8	11.8		11.8
5	Хурдан морины уралдааны газрын тохижилтийн дутуу	20.0	20.0	10.0	10.0
6	Зураг төсөв боловсруулах болон геологийн ажлын зардал	302.4	148.3	95.0	53.3
7	Бүтэн өнчин хүүхдэд "Хөх толбот" хадагламж	26.0	26.0	22.2	3.8
8	Аймгийн Засаг даргын нэрэмжит аваргын өсвөрийн гарaa жудо, чөлөөт, үндэсний бөхийн тэмцээн	30.0	30.0	22.8	7.2
9	Эрүүл мэнд хөтөлбөр	50.0	50.0	27.5	22.5
10	Боловсрол хөтөлбөр	100.0	100.0	53.4	46.6
	НИЙТ ДҮН				227.0

Сумдад дутуу олгосон санхүүжилт

сая. төгрөг

№	Сум	Анх батлагдсан 2015.03.30	Тодотгосон 2015.11.26	Тодотгосон 2015.11.26	Санхүүжсэн дүн	Дутуу санхүүжилт
1	Баруунтуруун	185.5	116.2	116.2	70.0	46.2
2	Бөхмөрөн	194.6	121.9	121.9	75.0	46.9
3	Давст	219.7	137.6	137.6	95.0	42.6
4	Завхан	251.9	157.7	157.7	110.0	47.7
5	Зүүнговь	176.9	110.8	110.8	95.0	15.8
6	Зүүнхангай	194.9	122.1	122.1	75.0	47.1
7	Малчин	186.7	116.9	116.9	80.0	36.9
8	Наранбулаг	217.7	136.3	136.3	90.0	46.3
9	Өлгий	164.9	103.3	103.3	65.0	38.3
10	Өмнөговь	206.3	129.2	129.2	100.0	29.2
11	Өндөрхангай	226.3	141.7	141.7	90.0	51.8
12	Сагил	182.5	114.3	114.3	90.0	24.3
13	Түргэн	187.0	117.1	117.1	82.0	35.1
14	Тариалан	140.4	87.9	87.9	87.9	
15	Тэс	219.9	137.7	137.7	127.0	10.7
16	Хяргас	190.1	119.1	119.1	75.0	44.1
17	Ховд	194.9	122.1	122.1	80.0	42.1
18	Цагаанхайрхан	189.0	118.4	118.4	75.0	43.4
19	Улаангом	954.2	597.3	597.3	496.0	101.3
	НИЙТ ДҮН	4483.5	2807.5	2807.5	2057.9	749.6

2.3. ОНХСангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг комисс хүлээн авсан ч зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

2.3.1. ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг эрх бүхий байгууллагаас томилогдсон комиссын дүгнэлтээр хүлээн авч ажилласан байна.

2.3.2. ОНХСангийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Няглан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө няглан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан журмын 8.6-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ” гэж заажээ. Гэтэл ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хийгдсэн зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байсныг данс бүртгэлд тусгахыг албан шаардлага болгов. Үүнд:

- ✓ Баруунтуруун сум спорт заалны засварын зураг төсөв 3.0 сая
- ✓ Аймгийн ЗДТГ-ын ариун цэврийн өрөөний их засварын 15.0 сая
- ✓ Биеийн тамир спортын газрын ариун цэврийн өрөөний их засвар 16.0 сая
- ✓ Тариалан сумын төвийн сайжруулсан шороон зам 10.0 сая, худгийн засвар 2.0 сая, нийт 12.0 сая

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээнээс нийт 46.0 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.
2. Аймаг, зарим сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд ямар ажил хийхийг тодорхой тусгаж батлаагүйгээс зориулалт бус зардал гарах эрсдэлийг үүсгэж байна.
3. Аймаг, зарим сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим төсөл, арга хэмжээний гэрээ, техникийн тодорхойлолт шаардлага хангахгүй байна.

Зөвлөмж: Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Үес аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, Засаг дарга Д.Цэндсүрэнд, сумдын Засаг дарга нарт

1. Няглан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалын зүйл заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгаж байх.

2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөтөлбөр, арга хэмжээг батлахдаа хийгдэх ажлыг тодорхой нэрчлэн тусгаж байх.
3. ТБОНӨХБАҮХАТ-ын хуулийн 11-р зүйлд заасан “Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд тавигдах шаардлагыг мөрдөж ажиллах”.

Бүлэг 3: ОНХС-ийн зарцуулалтад тавих хяналтыг зохион байгуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн ч зарим сүм, байгууллагын зүгээс тавих дотоод хяналт сүл байна.

3.1. ОНХС-ийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд хууль, журмын дагуу хяналт тавьсан байна.

3.1.1. Зарим сүм байгууллагын зүгээс ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд тавих дотоод хяналт сүл байна.

ТБОНӨХБАҮХАТ-ын 46.1.6-д “Захиалагч нь бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих” эрх үүрэгтэй гэж заасан байна.

Захиалагчийн хяналтын зардлыг аймгийн Худалдан авах ажиллагааны албанаас худалдан авах ажиллагааг зохион байгуулж шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа суутган тооцож ГХБХБГазарт шилжүүлэн хяналтыг хийлгэсэн байна.

Зарим сүм, байгууллагад эрх шилжсэн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтын зардлыг тооцоогүй бөгөөд мэргэжлийн бус хүмүүс захиалагчийн хяналтыг нэр төдий байгаагаас ажил чанаргүй хийгдэх, дутуу нийлүүлэгдэх, хугацаа хэтрэх эрсдэл гарч байна. Тухайлбал:

- Өлгий сум 2014 оны 8 сард ашиглалтанд оруулахаар гэрээ байгуулсан 77.9 сая төгрөгийн өртөгтэй “Б.Гиваан баатрын хөшөөт талбайг барих” ажлыг 2016 оны 4 сарын байдлаар бүрэн хийж хүлээлгэн өгөөгүй байсан зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өглөө.
- Улаангом sumaас Хотын хөгжил цэцэрлэгжүүлэлтийн газарт эрх шилжиж хийгдсэн 55 ширхэг хогийн сав нийлүүлэх 2015 оны 6 дугаар сарын 30-нд хүлээлгэн өгөх 17.2 сая төгрөгийн ажлыг ХХЦГ 2015 оны 7 дугаар сарын 15-нд хүлээн авсан байна.



- Малчин суманд 30.0 сая төгрөгийн өртөгтэй наадмын талбайн засварын ажлыг хийж 2015 оны 6 сард хүлээлгэн өгсөн боловч дээвэр нь хуурч нурсан байсанд засвар хийлгэхийг албан шаардлага болгов.



3.2. ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэж буй ажлын гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтыг олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

3.2.1. Аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалт төсөвт өртгийг иргэдэд мэдээлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн болон хийгдсэн ажлын мэдээллийг орон нутгийн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлсэн байна.

Аймгийн ОНХС, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр жил бүр хэлэлцэн үр дүнг тооцдог болсон байна.

Сумдын хувьд ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэх болон хийсэн ажлын жагсаалтыг гарган санал асуулгын хуудас дээр хэвлэж хүргүүлэх, багийн иргэдийн нийтийн хурлаар мэдээлэх, мэдээллийн самбарт байршуулах зэргээр иргэдэд мэдээлжээ.

3.2.2. Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Шилэн дансны тухай хуулийн шаардлагыг хангаж ажилласан байна.

Үвс аймгийн хэмжээнд 2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний батлагдсан жагсаалтыг uvs.tender.mn хаягаар анх батлагдсан болон тодотгосон байдлаар мэдээлсэн байна. ОНХС-ийн орлого, зарлагын санхүүжилтийн гүйлгээг Сангийн яамны mof.gov.mn вэб сайтад мэдээлсэн байна.

Аймгийн ОНХС болон сумдын ОНХС-ийн орлого, зарлагын болон худалдан авах ажиллагааны мэдээллийг аймгийн болон сумдын ЗДТГ-ын мэдээллийн самбар, байгууллагын вэб сайтаар мэдээлэх ажил хуулийн дагуу хийгдсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заасан байна. Зарим сум ОНХС-аар 2015 онд хийгдэх ажлын төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны мэдээллийг Өлгий, Ховд, Өмнөговь, Зүүнхангай сумдууд мэдээллийн самбарт байршуулаагүй байна.

3.3. Өмнөх оны аудитаар өгсөн акт 100 хувь, албан шаардлага 97.45 хувь, зөвлөмж 98 хувь хэрэгжүүлсэн байна.

3.3.1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

№	Зөвлөмжийн утга	Биелэлтийн хувь
1	Захиалагчийн үе шатны хяналт болон ажил дуусах үеийн хяналтыг тавих	100%
2	Захиалагчаас тавих хяналтыг сайжруулах	100%
3	Техникийн болон улсын комисс хууль журмын дагуу ажиллах	100%
4	Санхүүжилтийг Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу олгох.	100%
5	Тухайн жилд хэрэгжих боломжтой Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлыг урьд онд нь зохион байгуулж байх.	100%
6	Зураг, төсөв нь тодорхой болсон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж батлах.	100%
7	ЗДТГ-аас багийн иргэдийн саналыг эрэмбэлж ИТХ-д хүргүүлэхдээ эрэмбэ тогтоосон арга хэлбэр, байр суурь, зарчмыг тодорхой тайлагнасан илтгэх худас танилцуулж хэвших.	100%
8	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах	100%
9	ИТХ-аар батлагдсан арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлэх.	100%
10	ОНХС-ийн хөрөнгийг эзэнжүүлэх, малжуулах төспөөр хийгдэж байгаа гэрээг хамтран хариуцагчтай болгох.	80%
	Зөвлөмжийн биелэлт	98%

3.3.2. Аудитаар өгсөн 13 акт, 50 албан шаардлагыг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

№	Төлбөрийн акт	Биелэлтийн хувь
1	Өмнөговь сумын ОНХС-аас Дэвшил бага сургуульд авьяас, ном хөтөлбөрөөр 2,0 сая төгрөг олгосноос дугуйлан удирдсан багш нарт олгосон цагийн хэлс 1276,0 мянган төгрөгийг төвлөрүүлэх	100%
2	Малчин сум Нэхэн үржихүйн загвар эмнэлгийн санхүүжилтаар 14,0 сая төгрөг батлагдаж ирснээс 435,8 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсныг нэхэн төлүүлэх.	100%
3	Шин Тиан кэжи ХХК-тай ус зөөлрүүлэгч тоног төхөөрөмж 12.0 сая төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээ байгуулан гүйцэтгүүлж санхүүжилтийг 2013 оны 11-р сарын 25-нд 5.0 сая, 2014 оны 2-р сарын 12-нд 2.0 сая, 6-р сарын 10-нд 6.0 сая нийт 13.0 сая төгрөг шилжүүлж 1.0 сая төгрөг илүү олгосон	100%
4	Эрүүл мэндийн төвд "Нарлаг түрван хайрхан" ХХК Нэхэн үржихүйн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт шалгаран гүйцэтгэхдээ 100,0 мянган төгрөгийн өртөг бүхий нярайн ванныг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлээгүй байхад үнийг бүрэн төлсөн	100%
5	Малын чанар үүлдэр угсааг сайкруулах тендерээр иргэн Д.Мөнхбаяр ахлагчтай иргэдийн бүлэгтэй гэрээ байгуулан 9.8 сая төгрөгөөр 3 азарга худалдан авсан	100%
6	Хяргас сумын бөхийн клуб, үйлчилгээний төвийн засварын ажлын зураг төсөв боловсруулах ажлыг 3.6 сая төгрөгөөр ажлын 40 хоногт гүйцэтгүүлэхээр Х.Чинбаттай гэрээ байгуулан 2014 оны 3-р сарын 19-нд 1.8 сая төгрөг шилжүүлсэн боловч зураг нь хийгдэж ирээгүй	100%
7	"Сибтон" ХХК Эрүүл мэндийн төвд, гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт шалгаран гүйцэтгэхдээ махны машин, ширмэн тогоо, будаа агшаагчийг хэт өндөр үнээр нийлүүлсны үнийн зөрүү 500,0 мянган төгрөгийг нэхэн төлүүлэх.	100%
8	ахлах сувилагч С.Даваасүрэнгийн сургалтын төлбөр 85.0 мянга, НЭМАжилтан Н.Батхүрэлийн сургалтын төлбөр 192.0 мянган төгрөгийн сургалтын зардлыг орон нутгийн хөгжлийн сангаас төлсөн	100%
9	Улаангом сумын Засаг дарга "Гэрэлт шугам" ХХК-тай 2014 оны 05-р сарын 30-нд Улаангом сумын Малчин хорооллын цахилгаан хангамжийн ажил гүйцэтгэх тендерийн УГХА-06/2014/ дугаартай гэрээнд Малчин хорооллын цахилгаан хангамжийн ажил нийлүүлэх ажлыг 45147.7 мянган төгрөгөөр ашиглалтанд оруулахаар гэрээ байгуулжээ. 2014 оны 9-р сарын 29-нд комисс ажлыг хүлээн авч акт үйлджээ. Гэрээнд заасны дагуу эхийн санхүүжилтийг 2014 оны 6-р сарын 10-д олж суулийн санхүүжилтийг 9-р сарын 26-нд олж нийт 45147.7 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон боловч 2014 оны 10 сарын 02-ны Улаангом сумын Засаг даргын А/442 дугаар захирамжкаар Гэрэлт шугам ХХК-ны хүснэгт, валютын ханшны зөрүү, нэмэлт нийлүүлэлтийн үнийн зөрүү 2850.0 мянган төгрөгийг нэмж олгохоор захирамж гаргасны дагуу 11-р сарын 20-нд 2850.0 мянган төгрөгийг гэрээний дүнгээс илүү олгосон	100%

Үес аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны зарцуулалт

10	Соёлын төвд 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж авахаар ИТХ-аар баталсан байна. “Цуурай” ХХК-аас 8.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч, “Цавдан импекс” ХХК-д 2.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч хөрөнгийг нийлүүлэсгүй	100%
11	“Сээрийн Улаан хад” ХХК-тай гэрээ байгуулан Сумын ЭМТөвд 25433.5 мянган төгрөгийн нөхөн үржихүйн тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлж үнийг олгоходо ЭХО, УВЧ аппаратын сургалтанд хамрагдах эмчийг сургах зардал 415.0 мянган төгрөгийг ЭХО аппарат, УВЧ аппаратын үнийг нэмэгдүүлж орлого авч үнийг шилжүүлэн өгсөн байна. Засгийн газрын 2012 оны 30-р тогтоолоор удирдлагыг хэрэгжүүлэх зардалд сургалтын зардал орж байна. Сургалтын зардлыг орон нутгийн хөгжлийн сангаас төлсөн	100%
12	Эрүүл мэндийн төвд 491.6 мянган төгрөгийн шилэн хаалт хийлгэхээр мөнгийг нь гаргасан боловч шилэн хаалт нь хийгдээгүй байхад орлого авч данс бүртгэлд тусгасан	100%
13	19969.1 мянган төгрөгийн Давст сумын төсвийн 5 байгууллагын интернетийн сүлжээнд холбох ажлыг Женералтэх ХХК гүйцэтгэх гэрээ байгуулахдаа Интернетийн урсгалын 6 сарын төлбөр 1860.0 мянган төгрөгийг төлөх үүрэг хүлээсэн боловч төлбөрөө төлөөгүй	100%
Актын биелэлт		100%
Албан шаардлага		
1	Баян-Айраг багийн мал угаалгын ванн барих тендерт “Шанд туруун ” ХХК- 10000.0 мянга төгрөгөөр барихаар гэрээ байгуулан ажилласан байна. Гэтэл ажил нь хийгдээгүй байхад 4420.3 санхүүжилтийг олгосон байна. Манай байгууллагаас 2014 оны 11 сарын 7-ны 242 тоотоор гүйцэтгэл бүрэн дуусаагүй, комисс хүлээж аваагүй ажлын санхүүжилтийг олгохгүй байх зөвлөмж өгсөөр байтал ажил нь хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон	100%
2	Боловсрол шинжлэх ухааны яамнаас хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгөнөөс нэг бүр нь 990.0 мянган төгрөгийн үнэтэй чанга яриг 2 ширхэг нийт 1980.0 мянган төгрөгийн хөрөнгө ирсэн нь шатаж ашиглагдахгүй болсон, нийлүүлэгч байгууллагын зарлагын баримтанд 594.0 мянган төгрөгийн СД тоглуулагч ирсэн баримаа боловч хөрөнгө нь биетээр байхгүй	100%
3	“Таван цэрэг” ХХК-ний Гудамж талбайн тохиижилтоор хийгдсэн ажлаас нэг бүр нь 80.0 мянган төгрөгийн 12 ширхэг газарт суулгах гэрэл хийгдээгүй, “Ган зол” ХХК-ний Сургуулийн биеийн тамирын талбай тохижуулах ажлаар 6 гэрэл хийгдсэнээс 1 гэрлийн толгой унаж гэрэл ажиллахгүй байгаа	100%
4	Давст сумын засаг даргын 2014 оны 12 дугаар 24-ны өдрийн ДСХНГ-2014/02 тоот дугаартай “Соёлын төвд хөгжим нийлүүлэх бараа нийлүүлэх” гэрээний техникийн тодорхойлолтанд заасан 1000.0 мянган төгрөгийн үнэтэй 2500 марк DJ822FX маркын өсгөч пульт бэлтгэн нийлүүлэхээр гэрээ байгуулсан ч хүлээлгэн өгөөгүй	100%
5	Сумын дунд сургуулийн байр, дотуур байр, спорт заалны их засварын зураг хийлгэхээр “Байкал Борза” ХХК-тай гэрээ байгуулан 34000.0 мянган төгрөгийг төлсөн байна. Гэтэл Сургуулийн дотуур байрны зураг төсөөв байгаа боловч Сургуулийн байр, спорт заалны зураг байхгүй, Бүянт хусан ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн 12500.0 мянган төгрөгийг төсөөвт өртөгтэй зөөврийн малт тарилын хашаа хоёр айлын хашаанд бусдад ашиглагдаж байгаа	100%
6	ОНХСангаас шинээр төрж буй хүүхдэд нэг удаагийн тусламж дэмжлэг үзүүлэхэд 2250.0 мянган төгрөгийг олгож зориулалт бус зардал гаргасан байна	100%
7	“Завхан суль” ХХК-ний Эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг засварлах тендерт шалгарч 40.0 сая төгрөгөөр хийгдсэн ажлаас орох хаалганы дээд хэсэгт бүрхүүлтэй гэрэл тавих, гадна талыг тойруулж барисан төмөр хашааг ногоон, цэнхэр өнгөөр будах, халаалтын байрны зуухны яндан гарах хэсгийг засаж, галын аюулаас хамгаалах төмөр хамгаалалт хийж нүхийг багасгах, угаалгын өрөөний ханын өмхөрч муудсан хэсгийн засаж шавардаж будах зэрэг ажлууд дутуу хийгдсэн	100%
8	“Хүчит Хан Хөхий” ХХК-н Сургуулийн гал тогооны барилгыг засварлах тендерт шалгарч 25.0 сая төгрөгөөр хийгдсэн ажлаас Гадна, дотно засал, гал зуухны дотор хаалга, хувцасны өрөөний плита хийх, шал будах, уурын татаагуур хийх ажлууд дутуу хийгдсэн	100%
9	ОНХСангаас тэмээ өсгөх хөтөлбөрөөр 4284.0 мянга, иргэдийн санал аваагүй эрэмбэнд тусгагдаагүй Гэр худалдан авахад 24750.0 мянган төгрөгийг олгож зориулалт бус зардал гаргасан байна.	100%
10	Б.Дамжин ахлагчтай “Говийн төгөл” бүлэг Ахлах сургуулийн захирал Ж.Баянбилэгтэй сургуулийн ногоон байгууламжийг 17.0 сая төгрөгийн төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажилласан боловч ажлаа хийж гүйцээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон	100%
11	10.0 сая төгрөгийн төсөвтэй Эрүүл мэндийн төвийн ногоон байгууламжийг “Бүрэн дүүрэн цахиур” ХХК-ийн хийж гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж ажил бүрэн хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, 34.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй эхчүүдийн амрах байрыг Гончигсүм ХХК хийж гүйцэтгэн хүлээглэн өгсөн боловч халаалтын асуудал шийдвэрдээгүй ашиглалтанд бүрэн ороогүй, НҮЭМ-ийн загвар эмнэлэг хөтөлбөрийн хүрээнд 1.0 сая төгрөгийг сургалтын зардал санхүүжүүлэн олгосон	100%
12	Зүүнхангай сумын ОНХС-аас 2015 онд сумын ЗДТГазарт автомашин худалдан авахаар төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 60.4-д “Энэ хуулийн 60.3-1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй”	100%
13	2014 оны Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлыг иргэдээс санал авч эрэмбэлэсгүй, “Хөгжлийн хөтөч Зүүнхангайн хүүхдүүд” хөтөлбөрийн 20.0 сая төгрөгийн ажлыг тендер шалгаруулахгүйгээр 14 аж ахуйн нэгжтэй худалдах, худалдан авах гэрээ байгуулан хөрөнгө, материалын худалдан авалт хийсэн	100%
14	“Загир-Өлгий” ХХК-наас 13.7 сая төгрөгөөр Ахлах сургуульд “Авьяас, Ном” хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн хөрөнгөнөөс Онооны самбарын 3 даралт товч ажилгүй, металийн токарын машины оронд харуул хөрөө ирж түүний төхөөрөмж дутуу, хөрөөний гол гулзайсан, шанс цууралттай утас нь	100%

Үес аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны зарцуулалт

	чангардаггүй, ятганы утас чангардаггүй, самбо бөхийн өмсгөлийн оронд жудо бөхийн өмсгөл ирсэн, Р.Чойнямын “Сүмтэй будрын чулуу”, Д.Намдагийн “Манан будан”, Д.Ураанхайн “Эссэ бичвэр” зэрэг номууд дутуу ирсэн	
15	2014 онд орон нутгийн хөгжлийн сангаар хийх ажлыг багийн иргэдээс санал авсан боловч Багийн иргэдийн нийтийн хурал, сумын ЗДТГазар саналуудыг хээлцэж эрэмбэлж нэгтгээгүй, тендер шалгаруулж, гэрээ байгуулахдаа хийгдэх ажил, нийлүүлэх тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтод тодорхой зааж өгөөгүйгээс шаардлага хангахгүй бараа ажил үйлчилгээ нийлүүлэгдсэн, Эрүүл мэндийн төвөөс “Энгэлтэй” ХХК-д сувилалын хоолны материалын үнэд 1.0 сая, Соёлын төвийн тохиижилтын тендерт нийлүүлүүлсэн хөрөнгийн тэзвэр бензиний зардалд 240.0 мянган төгрөгийн урсгал зардал гаргасан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаа	100%
16	Халуун усыг 3.0 сая төгрөгөөр засвар хийж ашиглалтанд оруулсан боловч халаалтын системийг хөлдөөж халуун усыг ашиглалтгүй болсон	100%
17	Тэмүүлэл иргэний бүлэг наадмын талбайд ногоон байгууламж хийх тендерт шалгаран 2.7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж 2.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож талбайд дэвссэн хайргыг зөөж гарах ажил хийгдэх ногоон байгууламж хийдээгүй	100%
18	Өлгий сумын ахлах сургуулийн 1-р дотуур байр, хичээлийн 2-р байрны их засварын ажлын зураг төсөв боловсруулах ажлыг 5.0 сая төгрөгөөр 2015 оны 3-р сарын 1-ний дотор гүйцэтгүүлэхээр Бароккохийц ХХК Г.Баярхүүтэй Ахлах сургуулийн захирал гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгосон боловч зураг нь хийгдэж ирээгүй	100%
19	Б.Дээжидийн үр хүүхдүүдээс 35.0 сая төгрөгөөр хандивласан төр нийгмийн зүтгэлтэн Б.Дээжидийн хөшөө, 1988 оны төгсөгчдөөс 4.0 сая төгрөгөөр хандивласан Сумын төвийн өмнө талд босгосон хаалга, Орхон аймгийн нутгийн зөвлөлийн 9.78 сая төгрөгийн хандиваар хийсэн хүндэтгэлийн самбар, 1974 оны 8-р ангийн төгсөгчдөөс Сумын Засаг даргын тамын газарт хандивласан хүндэт самбар, Нэгдлийн дарга асан Жумдааны үр хүүхдүүдээс бэлэглэсэн 2.0 сая төгрөгийн том асар, 1986 оны 10 төгсөгчдөөс бэлэглэсэн 1.7 сая төгрөгийн 2 ш асар, Улиастай багийн угуул ахмад багш Сэмээхүүгээс бэлэглэсэн 500.0 мянган төгрөгийн “Британика” нэвтрэхий толь-8, Сүмбэрэлзулын бэлэглэсэн 150.0 мянган төгрөгийн 3 ш ном, Цоохүүгээс бэлэглэсэн 250.0 мянган төгрөгийн Монгол улсын түүхийн 5 боть, Х.Баянхишигийн хүүхдүүдээс 3.0 сая төгрөгөөр тохижуулсан Хүүхдийн тасаг нийт 58.4 сая төгрөгийн хөрөнгө хандиваар ирсэн боловч орлого авч, бүртгэлд тусгаагүй	100%
20	Ном авьяас хөтөлбөрөөр хувийн Дэвшил бага сургуульд 2.0 сая төгрөг олгосноос өнгөт альбом 20 ширхэг 500.0 мянга, 4 үйлдлээт хэвлэгч 224.0 мянган төгрөгийн нийт 724.0 мянга төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангаас хувийн хэвшилд хөрөнгө зарцууласан	100%
21	Орон нутгийн хөгжлийн сангаас Т.Нямынцурэнгийн Наадмын талбайг зулэгжүүлэх төслөөр хийгдсэн хөрөнгөнөөс 650.0 мянган төгрөгийн зүлэг тайрагч, А.Алимахуүгийн хэрэгжүүлсэн Хаягжуулалт төслөөр хийгдсэн ажлаас 2884.8 мянган төгрөгийн замын тэмдэг 16 ширхэг хийгдээгүй, ирээгүй	100%
22	Сумын эрүүл мэндийн төвд Нөхөн үргжихүй тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт шалгарсан “Сээрийн улаан хад” ХХК-аас нийлүүлсэн тоног төхөөрөмжкөөс 670.0 мянган төгрөгийн үнэтэй нярайн ванданг бэлтгэн нийлүүлэхээр гэрээ байгуулсан ч хүлээлгэн өгөөгүй	100%
23	Баянхайрхан багийн төвд Наадмын талбай барих тендерт “Баянт Харгуй” ХХК- 43911.2 мянган төгрөгөөр барихаар гэрээ байгуулан ажилласан байна. Гэтэл ажил нь гүйцэт хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна. Манай байгууллагаас 2014 оны 11 сарын 7-ны 242 тоотоор гүйцэтгэл бүрэн дусаагүй, комисс хүлээж аваагүй ажлын санхүүжилтийг олгохгүй байх зөвлөмж өгсөөр байтал ажил нь хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон	100%
24	ОНХСангаас сумын төвийн гудамжны гэрэлтуүлэгийн зардал 756.9 мянган төгрөгийг төлж зориулалт бус зардал гаргасан байна.	100%
25	Түргэн сумын Эрүүл мэндийн төвөөс багуудад эрүүл мэндийн чиглэлээр хийсэн сургалтын зардал 831.1 мянган төгрөгийг ОНХСангаас санхүүжүүлэн төлсөн байна	100%
26	сумын ЗДТГ-ын нягтлан бодогч Ц.Энхбаяр нь эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандаж аудитын цаг хугацааг саатуулсан	100%
27	Тэс сумын 90 жилийн ойгоор Ш.Түүвэйгийн үр хүүхдүүдээс 3.0 сая төгрөгөөр Түүхийн танхим тохиижуулах, 2014 оны 10 а ангийн төгсөгчдөөс 12.0 сая төгрөгөөр Хими, физикийн кабинет тохижуулах, Лхамсүрэнгийн үр хүүхдүүдээс 6.0 сая төгрөгөөр Орон нутаг судлах музеийн байр засварласан, М.Лхамсүрэнгийн үр хүүхэд төрөл төрөгсдөөс 13.0 сая төгрөг М.Лхамсүрэнгийн нэрэмжит танхим, үүдний самбар тохижуулсан, БСШУЯмнаас ирсэн Делл маркын 1175.0 мянган төгрөгийн 2 ш компьютер, шарп маркын 3509.1 мянган төгрөгийн хувилагчийг ирсэн боловч Ахлах сургууль орлого авч, бүртгэнд бүртгээгүй	34.8%
28	Тэс сумын 90 жилийн ойгоор М.Жамбалын хүүхдүүдээс 3.0 сая төгрөгийн проектор, дэлгэц, принтер хандиваар ирсэн боловч орлого авч, бүртгэлд тусгаагүй	100%
29	Тэс сумын 90 жилийн ойгоор 1987 төгсөгчдөөс 2.5 сая төгрөгийн проектор, дэлгэц, өнгөт принтер хандиваар ирсэн боловч орлого авч, бүртгэлд тусгаагүй	100%
30	Тэс сумын 90 жилийн ойгоор Намсаны хүүхдүүдээс 8.0 сая төгрөгөөр эхчүүдийн амрах байрны засвар тохиижилт, Ж.Гомбосүрэнгийн хүүхдүүдээс 6.0 сая төгрөгийн физик эмчилгээний тоног төхөөрөмж, 1999 оны төгсөгчдөөс 2.5 сая төгрөгийн өндөр насттан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрөө тохижуулах, 1999 оны төгсeltөөс 2.0 сая төгрөгийн Хүүхдийн өрөө тохижуулах, Аймгийн Засаг даргаас тусламжаар олгосон 8.0 сая төгрөгийн оношлогооны аппарат зэрэг нийт 26.5 сая төгрөгийн хөрөнгө хандиваар ирсэн боловч орлого авч, бүртгэлд тусгаагүй	100%

Үвс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны зарцуулалт

31	Тэс сумын 90 жилийн ойгоор Д.Буянжаргалаас 2.0 сая төгрөгөөр 11 ш морин хуур хөрөнгө хандиваар ирсэн боловч орлого авч, бүртгэлд тусгаагүй	100%
32	Тэс сумын 90 жилийн ойгоор Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлөөс 183.3 сая төгрөгөөр "Бахархалын талбай", С.Батнасан, Ч.Ядмаа нараас 20.0 сая төгрөгийн орох хаалга, 1992 оны төгсөгчдээс 7.5 сая төгрөгөөр 10 багийн даргад өгсөн мотоцикл, Л.Баяртайханаас 2.5 сая төгрөгөөр их гарын мастер морин хуур, Жигүүсэнээс 1.0 сая төгрөгөөр малгай хөрөнгө хандиваар ирсэн боловч орлого авч, бүртгэлд тусгаагүй	100%
33	Сайн үүлдрийн эцэг мал нийлүүлэхээр 12.0 сая төгрөгийг "Шар булаг" ХХК-д олгосон боловч хуцыг орлого аваагүй	100%
34	Улаангом сумын төв гудамжны ногоон байгууламжийг 28668.0 мянган төгрөгөөр "Увс ногоонтон хөдөлгөөн" ТББ хийж гүйцэтгэсэн ажлыг Хотын хөгжил цэцэрлэгжүүлэлтийн газар 22934.4 мянган төгрөгөөр бүртгэж тайлгасан	100%
35	47997.7 мянган төгрөгийн өртөгтэй "Гэрэлт шугам" ХХК-ний гүйцэтгэсэн Мал бүхий иргэдийн хорооллын цахилгаан шугам, 12160.0 мянган төгрөгийн өртөгтэй Жишиг хорооллын цахилгаан шугамыг Улаангом сумын Багийн хөрөнгөнд бүртгэгдсэн	100%
36	Улаангом сумын 1-р багийн нийтийн худагны гадна барилгын ажлыг Б.Доржтой гэрээ байгуулан 2450.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч 2000.0 мянган төгрөгөөр Улаангом сумын Багийн хөрөнгөнд бүртгэгдсэн	100%
37	Ногоонгом хөтөлбөрөөр 8528.3 мянга, Эрүүл хот хөтөлбөрөөр 23300.0 мянга, Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөрөөр 8161.8 мянган төгрөгийг бараа материалын үнэ, ажлын хэлс зэрэг урсгал зардлыг санхүүжүүлсэн, "Сайн тус төв" ТББ-д 2170.0 мянган төгрөгөөр Улаангом сумын иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах зардал нэрээр Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан журмын 4.4-д "Аймаг, сумын удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахгүй байх" гэж заасныг зөрчин 42160.1 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан	100%
38	Улаангом суманд Мал бүхий иргэдийн хорооллын 47997.7 мянган төгрөгийн ЦДАШ, Жишиг хорооллын 12160.0 мянган төгрөгийн цахилгаан шугам, Улиасны хэв, загвар шинэ орон сууchnы хороололд 27000.0 мянган төгрөгийн 0.3 км ЦДАШ, Цанын бааз, хог боловсруулах үйлдвэрийн төлөвлөгдсөн газар, Увс нуурын дэргэдэх аялал жуулчлалын гэр бааз, хурдан морины газрын чиглэлд 351481.1 мянган төгрөгийн ЦДАШ дэд станц, Ховд суманд 39500.0 мянган төгрөгийн ЦДАШ дэд станц, Давст суманд 39963.0 мянган төгрөгийн ЦДАШ дэд станц, Өндерхангай суманд 152243.4 мянган төгрөгийн ЦДАШ дэд станц, Цагаанхайрхан суманд 89500.0 мянган төгрөгийн ЦДАШ дэд станц нийт 759845.2 мянган төгрөгийн ЦДАШ, дэд станцыг данс бүртгэлд тусгаагүй	100%
39	Улаангом сумын Засаг дарга "Хүчит ханхөхий" ХХК-тай 2014 оны 12-р сарын 25-нд Бараа худалдах, худалдан авах 9.0 сая төгрөгийг сургуулийн емний насын болон бага ангийн сурагчдад зориулсан цохилтуул хөгжмийн зэмсэгийг 2014 оны 12-р сарын 31-нд нийлүүлэхээр гэрээ байгуулсныг 2014 оны 12-р сарын 30-нд хугацаа сунгасан нэмэлт гэрээ байгуулжээ. Уг гэрээнд барааг үнийн 30 хувь болох 2.7 сая төгрөгийн бараагаа нийлүүлсний дараа дансанд нь шилжүүлж өгнө гэж заасан боловч гэрээгээ зөрчиж бараа нийлүүлэгүй байхад үнийг бүрэн олгосон	37.7%
40	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 15.0 сая төгрөгөөр ахмадын байрыг Хайрхан уул аргажих ХХК-аас худалдан авсан боловч үйл ажиллагаа явуулж ашиглалтанд ороогүй, 2009 оны 9 сард Ахмадын байранд Тогтвортой амьжиргaa-2 төслөөр 1450.0 мянган төгрөгөөр тохижилт хийгдсэн хөрөнгийг сумын ЗДТГазрын эзэмшилд байхгүй	100%
41	Нарлаг турван хайрхан ХХК-наар нөхөн үржихүйн тоног төхөөрөмж нийлүүлэхэд 1480,0 мянган төгрөгийн эмийн хөргөгчийг нийлүүлсэн байхад орлогод аваагүй	100%
42	"Өндөрватт" ХХК- Соёлын төвийн гадна талбайн тохижилтын ажлыг 15.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажилласан боловч зурагт заасан ажлууд хийгдээгүй, гадна цементэн талбайн цементийн орц найрлагыг тохируулаагүй чанар муттай хийгдсэн	100%
43	Шин Тиан кэжи ХХК-аар Ус зөөлрүүлэгч тоног төхөөрөмжийг 12.0 сая төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ. Гэтэл ус зөөлрүүлэх тоног төхөөрөмж нь ашиглалдахгүй байгаа	100%
44	"Алдар булаг" ХХК-аар Гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлэгийн ажлыг 40.9 сая төгрөгөөр хийж гүйцэтгэх техникийн тодорхойлолтанд 32 ширхэг гэрлийн шон барьж хүлээлгэн өгсөн акт байгаа боловч бодит байдалд 31 шон буюу 1 шон дутагдаж байгаа	100%
45	Ногоон байгууламж хийх 10.0 сая төгрөгийн тендерт Д.Баянмөнх шалгаран хийж гүйцэтгэх техникийн тодорхойлолтанд заагдсан 400.0 мянган төгрөгийн усны нөөцийн сав 1 ширхэг дутуу байгаа	100%
46	Төсвийн тухай хуулийн 60.3.2-д "улс төрийн нам, төрийн бус байгууллагад зарлага гаргахыг хориглоно" гэж заасныг зөрчин Үндэсний бөхийн холбоонд дэмжлэг 7.0 сая төгрөгийг олгож зориулалт зардал гаргасан.	100%
47	Давст сумын ОНХС-аас санхүүжүүлсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрөөр 11,0 сая төгрөгийн зарцуулалтыг нягтлах ажлын хүрээнд ЭМТ-ын эрхлэг эмч Э.Олзбаатараас холбогдох мэдээллийг шаардахад тайлбар гаргаж өгөөгүйгээс шалтгаалан аудитын ажлын үдеэрширсан, улмаар Увс аймгийн тэргүүлэх аудитор Б.Авирамэд, Ахлах аудитор С.Алтанхундага, Шинжээч Я.Зунгарав нартай зүй бусаар харьцсан	100%
48	Давст сумын төсвийн 5 байгууллагын интернетийн сүлжээнд холбох ажлыг Женералтэч ХХК гүйцэтгэх гэрээ байгуулахдаа Интернетийн урсгалын 6 сарын төлбөр 1860.0 мянган төгрөгийг төлөх үүрэг хүлээсэн боловч телбөрөө төлөөгүй	100%
49	Давст суманд 79,9 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын гэрээ байгуулж гүйцэтгэгчид 18,0 сая төгрөгийн олгожээ.	100%

50	ЗДТГ-ын дарга Б.Цээлэйнамсан нь эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандаж аудитын цаг хугацааг саатуулсан	100%
	Албан шаардлагын биелэлт	97.45%

Дүгнэлт :

Аудитын явцад цуглувалсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Сумдын болон эрх шилжсэн байгууллагуудын зүгээс ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.
2. Өмнөх оны аудитаар өгсөн акт 100 хувь, албан шаардлага 97.45 хувь, зөвлөмж 98 хувь хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Үес аймгийн Засаг дарга Д.Цэндсүрэнд, сумын Засаг дарга нарт

1. ТБОНӨХБАҮХАТ хуулийн зүйл заалтыг мөрдөж ажиллах, захиалагчаас тавих хяналтыг сайжруулах.

Иргэдээс авсан санал асуулгын нэгтгэл

Таны оршин суугаа газар	Дүн
1. Хороо _____	Увс
2. Сум_____	19
3. Дүүрэг/Аймаг_____	
4. Таны нас_____	
5. Хүйс: 1.Эрэгтэй	170
2. Эмэгтэй	356
6. Боловсролын байдал_____	
7. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн ямар төсөл арга хэмжээ Танай хороо, сум, дүүрэгт хэрэгжих буй талаар Та хэр мэдээлэлтэй байна вэ?	
1. Санхүүжүүлж буй үйл ажиллагааны жагсаалт, хэрэгжилтийг сайн мэднэ	276
2. ОНХС-аас төсөл, арга хэмжээ санхүүжүүлдэг гэж сонссон, харин манай сум, дүүрэгт ямар арга хэмжээ хэрэгжих буйг мэдэхгүй	148
3. Энэ талаар огт мэдээлэл байхгүй	102
8. ОНХС-ийн асуудлыг хэлэлцэх баг, хорооны иргэдийн нийтийн хуралд Та оролцож байсан уу?	
1. Байнга	115
2. Хааяа	264
3. Огт үгүй	171
9. Хэрвээ оролцож байсан бол зайлшгүй шаардлагатай асуудлуудыг иргэдээр хэлэлцүүлж чаддаг эсэх талаар Таны бодол?	
1. Цаанаасаа бэлтгэсэн асуудлуудын жагсаалтыг хэлэлцүүлж санал авдаг	83
2. Оролцогч иргэдээс санал авч дэвшүүлэн хэлэлцүүлдэг	187
3. Дээрх хоёр аль аль нь	106
4. Иргэдийн саналыг бараг сонсдоггүй, нэр төдий хурал болдог	118
10. ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр болсон төсөл арга хэмжээний талаар мэдээллийг зарладаг уу?	
1. Тийм	274
2. Зарладаг байх, гэхдээ би сонсоогүй	197
3. Огт үгүй	53
11. ОНХС-аас ямар төсөл арга хэмжээ санхүүжүүлэх боломжтой тухай мэдээлэл болон таны саналыг авах хуудас Танай өрхөд ирж байсан уу?	
1. Саналын хуудас, мэдээлэл байнга ирдэг	129
2. Санал хуудас ирдэггүй ч хурал болох талаар мэдээлэл өгдөг	219
3. Санал хуудас ирдэггүй, мэдээлэл ч өгдөггүй	196
12. ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, ашиглалтад иргэд хяналт тавих бололцоо, механизм байгаа юу?	
1. Бүрэн боломжтой	226
2. Боломжгүй	98
3. Энэ талаар мэдэхгүй байна	222
13. ОНХС-ийн санхүүжилт, төсөл арга хэмжээний талаарх Таны нэмэлт санал хүсэлт?	

Холбогдох байгууллагын санал



УВС АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

213400, Улаангом, Үвс аймаг

Утас\Факс: 7045-2012

2016.04.29 № 2/399
таний _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдалд хийсэн тайлангийн төсөлтэй танилцлаа.

Дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.



2 670



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА УВС АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД

213400, Улаангом, Увс аймаг

2016. 04.29 № 152
танийн № -т

Г Аудитын тайландаа оруулах
санал

Аймгийн ИТХ нь Төсвийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан журмын хурээнд хөрөнгө оруулалтаар хийх ажлыг төлөвлөх, хэлэлцүүлэх талаар аймгийн Засаг даргад албан тоотоор Худалдан авах ажиллагаа. Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг ИТХ-ын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаж жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан тайланг нь тэргүүлэгчдийн хурлаар авч хэлэлцэн хяналт тавьж ажиллаж ирлээ.

Увс аймгийн ОНХС-ийн 2015 оны зарцуулалтанд хийсэн аудитын тайлангийн теселд дараах саналыг хүргүүлж байна.

1. 1.5-д байгаа "Аймаг" гэсэн үгийг хасах.
2. 1.5.2-д байгаа хурал дээр танилцуулагдаагүй үйл ажиллагааны талаарх дүгнэлтийг бүхэлд нь хасах. Орон нутгийн ЗДТГ-аас гэдгийг аймгийнх уу. Сумынх уу гэдгийг тодорхой болгох. Багийн ИНХ-аас хэлэлцэгдэж батлагдсан тесэл арга хэмжээг хэлэлцэж батлаагүй боловч тэр нь Сумын хөгжлийн стратегийт төлөвлөгөөнд тусгасан тесэл арга хэмжээ байж болно.
3. 1-р бүлгийн дүгнэлт хэсгийн 2-т: Сумын ОНХСанг хуваарилах аргачлалд сумын хөгжлийн индекс тооцох аргачлал тодорхой бус байгаагаас шалтгаалж зерүүтай тооцогдох тохиолдол байна.
- ✓ 4. 2.2.1-д Түргэн сумын иргэн Дариймааг ажил албан тушаал, овгоор нь тодорхой болгож бичих
5. Мөн 2.2.1-д Өлгий сумын малжуулах төслийн зөрчлийг арилгах, албан шаардлагыг "экт"-аар солих
6. 2-р бүлгийн дүгнэлт хэсгийн 1-ийн "85 хувь" гэснийг хасах, 3-д заасан тодорхой бус ерөнхий дүгнэлтийг бүхэлд нь хасах,

4-д заасан "зарим"-ыг дурьдаж тодруулах, шаардлагагүй бол хасах

7. 3-р бүлгийн 3.2.1-д "Аймгийн ОНХС, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр жил бүр хэлэлцэн үр дүнг тооцдог болсон байна" гэж нэмэх





УВС АЙМАГ
УЛААНГОМ СҮМЫН ЗАСАГ ДАРГА
213400, Улаангом, Увс аймаг
Утас/факс: 7045-3030

2016. 04. 29 № 471
танаи -ны № -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын жагсаалтын дараах асуудлуудыг сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 244-р тушаалын 12.2.4 дахь заалтанд "Сум, дүүргийн засаг даргаас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдсан төслийн санал болон иргэдийн нийтийн хурал дээр гарсан саналыг тухайн иргэдийн нийтийн хуралд хэлэлцүүлж тус хурлаас эрэмбэлэгдэж гарсан төслийн жагсаалтыг сум дүүргийн Засаг даргад 2 дугаар улиралд багтаан хүргүүлнэ" гэснийг үндэслэн сумын ИТХ-аар батлуулсан.

1. Улаангом хотын шинэчлэл-Хөгжлийн төлөө 2012-2016 оны сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 1-р бүлгийн 9,17-р заалтуудыг тус тус үндэслэн "Эрүүл хот" хөтөлбөрийн хүрээнд иргэдээс ирсэн хотын ёнге үзэмжийг сайжруулах гэсэн саналаар хийгдсэн ажлууд бөгөөд зах зээлийн үнэлгээний хамгийн хямдаар чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн.


2. Улаангом хотын шинэчлэл-Хөгжлийн төлөө 2012-2016 оны сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 1-р бүлгийн 29-р заалтыг үндэслэн сумын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрийг болосруулан "Баялаг бүтээгч Улаангом" хөтөлбөрийг хэвлүүлж сумын хөгжлийн төлөвлөгөөг иргэдэд хүргэж мэдээлэлээр хангах, цаашдын хөгжлийн зорилтод иргэдийн саналыг тусгах зорилгоор хэвлүүлсэн.

3. Улаангом хотын шинэчлэл-Хөгжлийн төлөө 2012-2016 оны сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 3-р бүлгийн 8-р заалтыг үндэслэн Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор үндэсний сурын шагнал болон Улаангом дэвжээг идэвхижүүлэх, нийтийн биеийн тамирын өдөрлөг зохион байгуулсан.

4. Улаангом хотын шинэчлэл-Хөгжлийн төлөө 2012-2016 оны сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 2-р бүлгийн 4,13-р заалтуудыг тус тус үндэслэн "Боловсрол" хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн Ахлах 4-р сургуулийн камержуулалт, 6-р

цэцэрлэгийн гадна тохижилтын ажил нь хүүхдийн сурч боловсрох нөхцлийг бүрдүүлсэн ажлууд гэж үзэж байна. Мен зах зээлийн үнэлгээнээс хямдаар хийх хүмүүстэй шууд гэрээ байгуулан ажилласан болно.

5. Улаангом сумын Засаг даргатай гэрээ байгуулан ажилласан "Хүчит Ханхөхий" ХХК-ийг шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлж байгаа болно.



Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны зарцуулалтанд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналын хариу.

- Аймгийн ИТХ-ын ирүүлсэн 7 саналд:
 1. 1.5-д тусгасан зөрчил нь аймаг, зарим сумдад хамаарч байгаа тул аймаг гэснийг хасах боломжгүй болно. Бүлгийн гарчигт засвар оруулав.
 2. 1.5.2-д байгаа Орон нутгийн гэснийг аймаг, зарим сумын болгон засвар орууллаа. Төсвийн тухай хуулийн 60.3.6-д “Орон нутгийн иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасныг зөрчсөн байх тул хасаж засвар оруулах боломжгүй болно. Мөн аймаг, сумын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн талаар тайлангийн 1.3-д тусгасан болно.
 3. 1-р бүлгийн дүгнэлт 2-т Төсвийн тухай хуулийн 59.2-т аймаг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сумын хөгжлийн санд хувиарлахаар заасныг зөрчиж “Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д 52.9 хувийг хуваарилсан” талаар тусгасан бөгөөд Энэ нь Засгийн газрын 2012 оны 30 тоот тогтоолоор баталсан аргачлалаас хамаarahгүй байна.
 4. 2.2.1-д Түргэн сумын иргэн Дариймаа гэснийг өндөр настан Н.Дариймаа болгон засвар оруулсан.
 5. 2.2.1-д Өлгий сумын малжуулахад зориулан иргэдэд 54.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосонд тухайн мал авсан иргэдтэй эргэн төлөлтийн гэрээ байгуулах албан шаардлага өгсөн бөгөөд тухайн зөрчил нь Төсвийн тухай хууль болон Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 тоот тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-д зааснаар төлбөрийн акт тавих хууль, эрх зүйн үндэсгүй байна.
 6. 2-р бүлгийн хувьд
 - дүгнэлт 1-д: Тайлангаас хасаж засвар оруулсан.
 - дүгнэлт 3-д: “Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд ямар ажил хийхийг тодорхой тусгаж батлаагүйгээс зориулалт бус зардал гарах эрсдэлийг үүсгэж байна” гэж тусгасан нь аймаг, сумдууд Боловсрол хөтөлбөр, Эрүүл мэнд хөтөлбөр, Нийтийн биеийн тамир хөтөлбөр, Эрүүл хот хөтөлбөр, Баялаг бүтээгч Улаангом хөтөлбөр зэргээр ямар төсөл, арга хэмжээнд зарцуулах нь тодорхойгүй мөнгө батлуулж урсгал үйл ажиллагаанд зориулалт бусаар зарцуулж байгаад өгсөн тодорхой дүгнэлт учир хасах шаардлагагүй байна. Холбогдох зөрчлийг тайландаа дэлгэрэнгүй тусгасан болно.
 - Дүгнэлт 4-д: “Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим төсөл, арга хэмжээний гэрээ, техникийн тодорхойлолт шаардлага хангахгүй

байна” гэж тусгасан бөгөөд холбогдох зөрчлийг тайланд тодорхой тусгасан учир дүгнэлтэд дахин дурьдах шаардлагагүй болно.

7. З-р бүлгийн 3.2.1-д “Аймгийн ОНХС, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр жил бүр хэлэлцэн үр дүнг тооцдог болсон байна” гэж нэмэж оруулах саналын дагуу тайланд нэмж оруулсан.

- Аймгийн ЗДТГ-ын даргын ирүүлсэн саналд:

Тайлангийн төсөлтэй санал нэг байна гэсэн албан тоот ирсэн тул хариу тайлбар өгөх шаардлагагүй.

- Улаангом сумын Засаг даргын ирүүлсэн саналд:

1. Улаангом сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хийгдэх ажлыг 2012, 2013 онд авсан иргэдийн саналд үндэслэн батласан байна.
2. Эрүүл хот хөтөлбөр, Баялаг бүтээгч Улаангом хөтөлбөр, Нийтийн биеийн тамир хөтөлбөр, боловсрол хөтөлбөрүүд нь иргэдийн санал аваагүй байсан болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АХЛАХ ШИНЖЭЭЧ
АУДИТОР
ШИНЖЭЭЧ

С.АЛТАНХУНДАГА
М.БАТСУУРЬ
Т.НАМЖИЛ
С.БАТСАЙХАН
Я.ЗУНГАРАВ